

## ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад шуудангийн үйлчлэгчийн сүлжээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, "үйлчилгээ эрхлэгчдэд" нээлттэй, шударга нөхцөлөөр салбарын өрсөлдөөнийг дэмжихэд оршино.
- 1.2. Шуудангийн үйлчлэгч (Цаашид Үйлчлэгч гэх) нь сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ үйлчилгээ хооронд нийтийн шуудангийн үйлчилгээг үзүүлэх харилцан холболт хийхдээ Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, шуудангийн стандарт<sup>1</sup> болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.3. Энэхүү журам нь Дэлхийн шуудан холбооны дүрэм, конвенцийн дагуу хийгддэг олон улсын шуудан солилцооны харилцан холболттой холбоотой харилцааг зохицуулахгүй.
- 1.4. Энэхүү журмаар шуудангийн сүлжээ хооронд, үйлчилгээ үйлчилгээ хооронд харилцан холболт хийх, шуудангийн сүлжээ үйлчилгээ хооронд холболт хийх гэрээний нөхцөл тогтоох, холболт хийх төлбөр болон харилцан холболт хийх төлбөр, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.

### ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Үйлчлэгч нь харилцан холболт хийх болон холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байна.
- 2.2. Үйлчилгээнд нөлөөлөх, эсвэл үйлчилгээг тасалдуулж болзошгүй саатал болон амралтын үеийн хуваарийг талууд яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авна.
- 2.3. Үйлчлэгч нь шуудангийн сүлжээ хооронд харилцан холболт, үйлчилгээ үйлчилгээ хооронд харилцан холболт хийх ерөнхий нөхцлийг (RIO<sup>2</sup>)

---

<sup>1</sup>MNS 5539:2019 Шуудангийн аюулгүй байдал;  
MNS 6775:2024 Хаяг, хаягийн бичвэрт тавих шаардлага;  
MNS 6776:2009 Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага;  
MNS 5380-1:2004 Шуудангийн хэрэглэгдэхүүн. 1-р хэсэг. Шуудангийн тэмдэг;  
MNS 5380-2:2004 Шуудангийн хэрэглэгдэхүүн. 2-р хэсэг. Шуудангийн маягт.

<sup>2</sup> A Reference Interconnection Offer (RIO)

боловсруулан Зохицуулах хорооны ажлын албанд ирүүлж, хянуулан баталж, өөрийн цахим хуудсанд байршуулах бөгөөд сүлжээ хооронд харилцан холболт, үйлчилгээ үйлчилгээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- 2.3.1. Зааглах цэгийн байршил;
  - 2.3.2. Харилцан холболт хийх төлбөр, тооцооны мэдээлэл;
  - 2.3.3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;
  - 2.3.4. Гэрээний загвар.
- 2.4. Үйлчлэгч нь шуудангийн сүлжээ үйлчилгээ хооронд холболт хийх гэрээний нөхцөлийг (RAO<sup>3</sup>) боловсруулан Зохицуулах хорооны ажлын албанд ирүүлж, хянуулан баталж, өөрийн цахим хуудсанд байршуулах бөгөөд сүлжээ үйлчилгээ хооронд холболт хийх гэрээний нөхцөлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
- 2.4.1. Зааглах цэгийн байршил;
  - 2.4.2. Холболт хийх төлбөр, тооцооны мэдээлэл;
  - 2.4.3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;
  - 2.4.4. Гэрээний загвар.
- 2.5. Үйлчлэгч нь илгээмжийн бүртгэл, хяналтын системийн найдвартай аюулгүй байдлыг хангаж ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас үүссэн хохирлыг хариуцна.

#### ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1. Талууд зааглах цэгээс эхлэн тус тусын ашиглалт үйлчилгээ, илгээмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцна.
- 3.2. Харилцан холболтын үйлчилгээний чанарын үзүүлэлтийг өөрийн чанарын үзүүлэлтээс бууруулахгүй байна.

#### ДӨРӨВ. ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

- 4.1. Харилцан холболтын технологийн нөхцөл нь шуудангийн үйлчилгээний аюулгүй байдлын стандартыг хангасан байдал, шуудангийн илгээмжийг хүргэх хугацааны үзүүлэлтүүд байна.

---

<sup>3</sup> A Reference Access Offer (RAO)

- 4.2. Шуудангийн харилцан холболтын илгээмжийн бүртгэл, хяналтын төлөвийн мэдээллийг харилцан холбогдогч талд бодит хугацаанд системээр солилцох боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.3. Талууд нь өөрийн сүлжээ, үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх, татан буулгах зэрэг өөрчлөлтөөс үүдэн харилцан холболтод нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсэхээр бол мэдээллийг 3 сарын өмнө холбогдох талуудад болон Зохицуулах хорооны ажлын албанд мэдэгдэнэ.
- 4.4. Харилцан холболтын явцад шинэ технологийг нэвтрүүлэхтэй холбоотой нэмэлт хөрөнгө оруулалт, зардлыг талууд харилцан тохиролцоно.

#### ТАВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

- 5.1. Шуудангийн сүлжээ хооронд, үйлчилгээ үйлчилгээ хооронд харилцан холболт хийх, шуудангийн сүлжээ үйлчилгээ хооронд холболт хийх харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7, 22.3 заалтын дагуу Зохицуулах хороо энэхүү журмыг баримтлан дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
  - 5.1.1. Зааглах цэг нь илгээмж солилцох байр талбай, тээврийн хэрэгсэл, шуудангийн ухаалаг хайрцаг, талуудын үйлчилгээний салбар, цэг байна.
  - 5.1.2. Зааглах цэгт солилцох шуудангийн илгээмж нь стандартын дагуу бэлтгэгдсэн байна.
- 5.2. Үйлчлэгч нь зааглах цэгт илгээмжийн тоо, жин, дамжуулалтын мэдээллийг шуудангийн гардуулалтын дагавар болон илгээмжийн бүртгэл, хяналтын системээр баталгаажуулна.

#### ЗУРГАА. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

- 6.1. Гэрээнд технологийн болон дараах нөхцөлүүдийг тусгана. Үүнд:
  - 6.1.1. Шуудангийн хүргэлтийн график маршрут, хүргэх хугацаа, зааглах цэг, төлбөр тооцооны мэдээлэл, нийлэх хугацаа;
  - 6.1.2. Үйлчилгээний өртөгт үндэслэн тооцоолсон үнэ тариф;

- 6.2. Үйлчлэгч нь үйлчилгээний өртгийг тооцохдоо хамрах хүрээ, илгээмжийн төрөл, технологийн шат дамжлага, илгээмжийн ширхэг, жингийн шатлал, хүргэлтийн хугацаа, зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 6.3. Харилцан холболтын төлбөрийг солилцсон шуудангийн гадуур болон дотуур дагавар, бүртгэл хяналтын системийн мэдээлэлд үндэслэн тооцно.
- 6.4. Гэрээнд депозит байршуулах нөхцөлийг нэмэлтээр тусгаж болно.
- 6.5. Харилцан холболтын гэрээг энэхүү журмын дагуу зөвхөн бичгээр, Монгол хэлээр байгуулна.
- 6.6. Үйлчлэгч нь харилцан холболтын гэрээг байгуулахаас өмнө Зохицуулах хорооны ажлын албанд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.
- 6.7. Үйлчлэгч харилцан холболт хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор гэрээ байгуулна.
- 6.8. Харилцан холболтын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор гэрээ болон түүний хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хорооны ажлын албанд ирүүлж, бүртгүүлэх ба гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон тухай бүрт бүртгүүлнэ.
- 6.9. Зохицуулах хороо нь энэхүү журмын дагуу байгуулаагүй харилцан холболтын гэрээг бүртгэхээс татгалзах эрхтэй бөгөөд үйлчлэгч нь гэрээг энэхүү журамд нийцүүлэн байгуулж, дахин бүртгүүлэхээр хандана.
- 6.10. Зохицуулах хороо нь харилцан холболтын гэрээний бүртгэлийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

#### ДОЛОО. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮЛЭЭН АВАХ, ХАРИУГ ӨГӨХ

- 7.1. Үйлчлэгч нь харилцан холболт хийх хүсэлтийг бичгээр болон цахим шуудангаар хүргүүлнэ.
- 7.2. Үйлчлэгч нь өөр хоорондоо харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 5 хоногийн дотор хариуг мэдэгдэнэ.
- 7.3. Үйлчлэгч нь харилцан холболт хийх боломжгүй гэж үзсэн тохиолдолд уг шийдвэрийн үндэслэл, шалтгаан болон нөхцөлийг бүрдүүлэх боломжийн

тодорхой дурдсан тайлбарыг 3.2-т заасан хугацаанд хүсэлт гаргагчид хүргүүлж, хуулбарыг Зохицуулах хорооны ажлын албанд ирүүлнэ.

- 7.4. Зохицуулах хорооны ажлын алба тохиролцоонд хүрээгүй асуудлаар талуудын тус бүрийн саналыг авч мэргэжлийн баг бүрдүүлэн ажиллаж, дүгнэлт шийдвэрийг гарган талуудыг харилцан холбогдох боломжийг бүрдүүлнэ.
- 7.5. Үйлчлэгч нь дээрх дүгнэлт шийдвэрийг үндэслэн холбогдох технологийн болон бусад нөхцөлийг бүрдүүлж гэрээг байгуулна.

#### НАЙМ. ГЭРЭЭГ ХЯНУУЛАН БАТЛУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1. Зохицуулах хорооны ажлын алба үйлчлэгчид холболт хийх болон харилцан холболтын гэрээг хянуулж, бүртгүүлэх тухай мэдэгдлийг гэрээний хамт хүргүүлнэ.
- 8.2. Үйлчлэгч холболт хийх болон харилцан холболтын гэрээг бүртгүүлэхээр Зохицуулах хорооны ажлын албанд ирүүлнэ.
- 8.3. Үйлчлэгчээс ирүүлсэн хүсэлтийг Зохицуулах хорооны ажлын алба хүлээн авч, гэрээ харилцан холболтын журам, ерөнхий нөхцөлд нийцэж буй эсэхийг маягтын дагуу үнэлнэ.
- 8.4. Үнэлгээний үр дүнд харилцан холболтын гэрээг бүртгэлийн санд бүртгэж, цахим хуудсанд мэдээлнэ.
- 8.5. Харилцан холболтын гэрээний маргаантай асуудлыг Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.12, 31.2-т заасны дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.
- 8.6. Энэхүү журмын 6.9 дах заалтын дагуу бүртгүүлээгүй гэрээг бүртгэхээс татгалзах бөгөөд бүртгэгдээгүй харилцан холболтын гэрээтэй холбоотой үүссэн маргааныг Зохицуулах хороо шийдвэрлэхгүй.
- 8.7. Маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Зохицуулах хороо дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд:
  - 8.7.1. Маргаантай асуудлыг судлахын тулд шаардлагатай мэдээллийг талуудаас авч судлах, дүн шинжилгээ хийх, баримт гаргаж тавих;
  - 8.7.2. Талуудын тайлбар, саналыг сонсох, шаардлагатай гэж үзвэл олон нийтийн санал авах, хяналт, шалгалтыг хийх;

- 8.7.3. Ижил төстэй байгууллагууд болон олон улсын туршлагыг судлан харьцуулалт хийх, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган ажиллуулах;
- 8.7.4. Маргалдагч талуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг санаачлан байгуулж, тухайн асуудлаар санал солилцуулан нэгдсэн шийдвэрт хүргэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах.
- 8.8. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх, гэрээг дахин авч үзэх тухай хугацаатай үүрэг даалгавар өгөх, маргааныг шийдвэрлэж болох хувилбаруудыг санал болгох зэргээр тодорхой шийдвэрийг гаргана.
- 8.9. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар тухайн нөхцөл байдалд тохируулан үл ялгаварлах, шударга, өрсөлдөөнийг дэмжсэн шийдвэр гаргах ба шийдвэрийн талаар талуудад урьдчилан танилцуулж, саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх замаар ил тод зарчмыг баримтална.
- 8.10. Маргалдагч талууд Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг хүлээж авахыг эрмэлзэх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

#### ЕС. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

- 9.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

--- оОо ---